



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/387 дугаар захирамжийн 1 дэх хэсэг, 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 7.1.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мопед (скүүтер боон түүнтэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл) түрээслүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн саналын дагуу тус газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/25 тушаалын хоёрдугаар хавсралтын 9 дэх хэсэгт “Гэнэтийн ослын даатгалын гэрээ” гэснийг хассугай.

2.Тушаалын өөрчлөлтийг ажлын хэсгийн гишүүд, түрээслүүлэгч байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (А.Алтанцоож) -д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г БИЛГҮҮН

